



**НИЙСЛЭЛИЙН  
АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цагаан сар”-ын баярын өдрийг тохиолдуулан тус байгууллагад ажиллаж байсан ахмад настан Чойжилын Сэдэдийг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, тэтгэмж олгож, бэлэг дурсгалын зүйлс гардуулсугай.

2. Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор шаардагдах 400 000 /дөрвөн зуун мянга/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Цэцэгмаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЦАЦРАЛ